**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/115/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025.02.25 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Г.Энхзул<br>Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 7

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .......... 14

**4. АУДИТЫН ТАЙЛАН** .......... 17

**4.1 Ерөнхий зүйл** .......... 17

**4.2 Материаллаг байдал** .......... 17

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** .......... 17

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** .......... 17

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** .......... 18

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** .......... 18

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** .......... 18

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/30

танай___________-ны № ___________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮҮХЭД,
ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН
ГАЗРЫН ДАРГА Н.МЭНДБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020219

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь өөрийн харьяаны "Өвгөнжаргалант" хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны орлого, зардлыг төлөвлөхгүй зөвхөн гүйцэтгэлээр тайлагнаж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98,9% хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **91,623,648.19** | **123,988,648.28** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 91,623,648.19 | 123,988,648.28 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,856,000.00 | 6,011,400.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,475,000.00 | 5,496,400.00 |
| 35130 | Эм боох материал | 381,000.00 | 515,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 87,767,648.19 | 117,977,248.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 444,890.00 | 2,457,670.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,996,199.18 | 24,394,378.27 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 63,000.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 351,559.01 | 267,300.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 70,912,000.00 | 90,857,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **472,591,728.07** | **454,590,089.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 472,591,728.07 | 454,590,089.80 |
| **392** | **Биет хөрөнгө** | 392,681,727.95 | 374,735,089.64 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 268,144,869.83 | 268,144,869.83 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (40,174,588.68) | (51,652,741.44) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,965,000.00 | 34,965,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (16,860,583.03) | (21,023,416.49) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 138,786,845.00 | 161,710,952.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (96,466,764.73) | (106,620,123.18) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 148,768,447.45 | 153,166,447.45 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (69,975,454.45) | (87,238,128.73) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 36,925,445.00 | 33,175,895.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (12,596,455.44) | (11,058,631.80) |
| 39217 | Ном | 1,164,967.00 | 1,164,967.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 79,910,000.12 | 79,855,000.16 |
| 39301 | Программ хангамж | 900,000.00 | 725,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (789,999.88) | (669,999.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 79,800,000.00 | 79,800,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **564,215,376.26** | **578,578,738.08** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,658,246.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,658,246.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 1,658,246.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,658,246.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,658,246.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **562,557,130.26** | **578,578,738.08** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 562,557,130.26 | 578,578,738.08 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 94,718,933.00 | 94,718,933.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 94,718,933.00 | 94,718,933.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 301,282,110.74 | 317,588,718.56 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 301,282,110.74 | 301,567,110.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 16,021,607.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 166,556,086.52 | 166,271,086.52 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **564,215,376.26** | **578,578,738.08** |



005

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,340,685,399.30** | **1,816,155,444.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **144,467,566.30** | **5,772,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 144,467,566.30 | 5,772,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 144,405,986.30 | 5,721,300.00 |
| 120009 | Бусад орлого | 61,580.00 | 51,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,196,217,833.00** | **1,810,319,102.86** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 869,947,700.00 | 1,453,756,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 869,947,700.00 | 1,453,756,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 324,797,872.00 | 356,562,502.86 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 45,325,837.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 136,842,975.00 | 89,986,610.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 187,954,897.00 | 221,313,897.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,472,261.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,472,261.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,201,542,226.46** | **1,800,133,836.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,201,542,226.46** | **1,800,133,836.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,187,648,643.27 | 1,548,075,920.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343,234,782.90 | 541,068,649.29 |
| 210101 | Үндсэн цалин | 337,982,017.90 | 453,768,727.20 |
| 210102 | Нэмэгдэл | 4,301,765.00 | 47,432,985.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 951,000.00 | 31,578,937.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 8,288,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,622,454.11 | 72,239,573.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,307,629.53 | 50,867,808.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,937,895.63 | 5,309,307.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,795,288.10 | 2,909,892.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 689,021.30 | 2,570,058.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,892,619.55 | 10,582,507.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,902,318.20 | 65,159,164.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,133,214.56 | 5,257,014.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,373,475.64 | 56,980,110.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,395,628.00 | 2,922,040.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,251,454.70 | 7,883,809.91 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,639,009.00 | 1,145,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,230,465.90 | 1,655,589.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,045,899.80 | 1,194,420.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,195,300.00 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,540,780.00 | 2,688,180.91 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 63,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 63,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 312,900.00 | 00.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 210,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 102,900.00 | 00.00 |



005

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 698,329,185.20 | 810,985,280.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 697,763,285.20 | 810,514,080.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 102,900.00 | 245,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 85,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 38,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 155,000.00 | 155,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 190,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,995,548.16 | 50,676,443.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,380,000.00 | 1,350,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,615,548.16 | 49,326,443.27 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,893,583.19 | 252,057,915.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 38,186,770.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 36,886,770.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,300,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,393,583.19 | 213,871,145.89 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **139,143,172.84** | **16,021,607.82** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **139,143,172.84** | **16,021,607.82** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,196,279,413.00** | **1,810,434,144.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **61,580.00** | **51,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 61,580.00 | 51,200.00 |
| 120009 | Бусад орлого | 61,580.00 | 51,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,196,217,833.00** | **1,810,382,944.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 869,947,700.00 | 1,453,756,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 869,947,700.00 | 1,453,756,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 324,797,872.00 | 356,626,344.50 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 45,325,837.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 136,842,975.00 | 89,986,610.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 187,954,897.00 | 221,313,897.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,472,261.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,472,261.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,174,196,113.00** | **1,781,267,339.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,174,196,113.00** | **1,781,267,339.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,160,302,529.81** | **1,528,472,965.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 342,751,736.17 | 542,360,389.61 |
| 210101 | Үндсэн цалин | 214,863,876.90 | 281,986,008.02 |
| 210102 | Нэмэгдэл | 83,415,947.67 | 169,717,765.64 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,361,245.60 | 55,174,269.45 |
| 210104 | Урамшуулал | 22,110,666.00 | 35,482,346.50 |



005
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,855,401.64 | 66,647,362.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,860,924.52 | 45,658,850.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,508,498.04 | 5,247,078.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,806,734.42 | 2,623,539.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 701,583.61 | 2,623,639.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,977,661.05 | 10,494,256.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,902,318.20 | 64,942,244.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,133,214.56 | 5,257,014.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,373,475.64 | 56,980,110.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,395,628.00 | 2,705,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,121,599.80 | 7,417,920.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 452,800.00 | 2,955,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 786,700.00 | 1,471,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 645,399.80 | 994,220.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 236,700.00 | 800,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 1,196,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 80,000.00 | 2,754,950.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,577,500.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 894,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 172,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 80,000.00 | 109,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 102,900.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 102,900.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 724,108,574.00 | 843,000,099.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 723,806,674.00 | 842,412,699.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 102,900.00 | 245,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 20,500.00 | 20,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 86,600.00 | 38,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 58,900.00 | 251,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,380,000.00 | 1,350,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,380,000.00 | 1,350,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,893,583.19** | **252,794,373.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 38,923,228.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 37,523,228.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,393,583.19 | 213,871,145.89 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **22,083,300.00** | **29,166,805.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **22,083,300.00** | **29,166,805.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,083,300.00** | **29,166,805.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 22,083,300.00 | 29,166,805.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 22,083,300.00 | 29,166,805.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(22,083,300.00)** | **(29,166,805.00)** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 94,718,933.00 | 166,556,086.52 | 162,138,937.90 | 00.00 | 423,413,957.42 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **94,718,933.00** | **166,556,086.52** | **162,138,937.90** | **00.00** | 423,413,957.42 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 139,143,172.84 | 00.00 | 139,143,172.84 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,718,933.00** | **166,556,086.52** | **301,282,110.74** | **00.00** | 562,557,130.26 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,718,933.00** | **166,556,086.52** | **301,282,110.74** | **00.00** | 562,557,130.26 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 285,000.00 | 00.00 | 285,000.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **94,718,933.00** | **166,556,086.52** | **301,567,110.74** | **00.00** | 562,842,130.26 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | (285,000.00) | 00.00 | 00.00 | (285,000.00) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 16,021,607.82 | 00.00 | 16,021,607.82 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,718,933.00** | **166,271,086.52** | **317,588,718.56** | **00.00** | 578,578,738.08 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,453,756,600.00 | 1,239,949,295.75 | 213,807,304.25 | 85.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,453,756,600.00 | 1,239,949,295.75 | 213,807,304.25 | 85.29 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,407,098,300.00 | 1,201,026,067.75 | 206,072,232.25 | 85.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 520,224,000.00 | 520,203,353.75 | 20,646.25 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 303,177,000.00 | 281,986,008.02 | 21,190,991.98 | 93.01 |
| 210102 | Нэмэгдэл | 167,423,200.00 | 148,349,741.78 | 19,073,458.22 | 88.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,306,100.00 | 55,174,269.45 | (35,868,169.45) | 285.79 |
| 210104 | Урамшуулал | 30,317,700.00 | 34,693,334.50 | (4,375,634.50) | 114.43 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,028,000.00 | 65,028,000.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,219,000.00 | 44,219,000.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,202,200.00 | 5,202,200.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,601,100.00 | 2,601,100.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,601,200.00 | 2,601,200.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,404,500.00 | 10,404,500.00 | 0.00 | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 67,136,800.00 | 64,942,244.00 | 2,194,556.00 | 96.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,482,000.00 | 5,257,014.00 | 224,986.00 | 95.90 |
| 210302 | Түлш, халаалт | 55,126,500.00 | 56,980,110.00 | (1,853,610.00) | 103.36 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,528,300.00 | 2,705,120.00 | 3,823,180.00 | 41.44 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,433,700.00 | 7,366,720.00 | 66,980.00 | 99.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,962,000.00 | 2,931,100.00 | 30,900.00 | 98.96 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,471,500.00 | 1,471,500.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,003,900.00 | 967,820.00 | 36,080.00 | 96.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,196,300.00 | 1,196,300.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 30,565,800.00 | 30,511,950.00 | 53,850.00 | 99.82 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,715,000.00 | 24,714,500.00 | 500.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 5,542,600.00 | 5,514,800.00 | 27,800.00 | 99.50 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 215,800.00 | 172,800.00 | 43,000.00 | 80.07 |
| 210604 | Урсгал засвар | 92,400.00 | 109,850.00 | (17,450.00) | 118.89 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 100,900.00 | 00.00 | 100,900.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 100,900.00 | 00.00 | 100,900.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 715,251,700.00 | 511,623,800.00 | 203,627,900.00 | 71.53 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 714,394,300.00 | 511,036,400.00 | 203,357,900.00 | 71.53 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 245,200.00 | 245,200.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,300.00 | 00.00 | 30,300.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 20,100.00 | 20,100.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 36,400.00 | 33,000.00 | 3,400.00 | 90.66 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 85,000.00 | 38,000.00 | 47,000.00 | 44.71 |
| 210807 | Газрын төлбөр | 440,400.00 | 251,100.00 | 189,300.00 | 57.02 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1357,400.00 | 1,350,000.00 | 7,400.00 | 99.45 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,357,400.00 | 1,350,000.00 | 7,400.00 | 99.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 46,658,300.00 | 38,923,228.00 | 7,735,072.00 | 83.42 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 46,658,300.00 | 38,923,228.00 | 7,735,072.00 | 83.42 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,186,800.00 | 37,523,228.00 | 7,663,572.00 | 83.04 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,471,500.00 | 1,400,000.00 | 71,500.00 | 95.14 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,453,756,600.00 | 1,239,949,295.75 | 213,807,304.25 | 85.29 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,453,756,600.00 | 1,239,949,295.75 | 213,807,304.25 | 85.29 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,453,756,600.00 | 1,239,949,295.75 | 213,807,304.25 | 85.29 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 10.00 | 00.00 | 10.00 | 0.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 00.00 | 10.00 | 0.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **356,626,344.50** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **356,626,344.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 356,562,502.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 22,157,035.86 |
| 210102 | Нэмэгдэл | 21,368,023.86 |
| 210104 | Урамшуулал | 789,012.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,619,362.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,439,850.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 44,878.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,439.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 22,439.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 89,756.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 332,786,104.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 332,786,104.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **63,841.64** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **63,841.64** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт | 63,841.64 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 356,626,344.50 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 356,626,344.50 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,325,837.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 89,986,610.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 221,313,897.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар нь эрхэм зорилгоо "Гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж тэднийг хөгжих таатай орчин бий болгоход оршино" гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аудит хийх хугацаанд дотоод аудитын чиг үүргийг Баянхонгор аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлж байгаа бөгөөд аудитын тайлан нь эцэслэж гараагүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 578,578.7 мянган төгрөг болж өмнөх оноос 14,363.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **91,623.60** | **123,988.60** | **32,365.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 91,623.60 | 123,988.60 | 32,365.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **472,591.70** | **454,590.10** | **(18,001.60)** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 472,591.70 | 454,590.10 | (18,001.60) |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (236,863.80) | (278,263.00) | (41,399.20) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **564,215.40** | **578,578.70** | **14,363.30** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,658.20** | **00.00** | **(1,658.20)** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,658.20 | 00.00 | (1,658.20) |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **562,557.10** | **578,578.70** | **16,021.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 562,557.10 | 578,578.70 | 16,021.60 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 301,282.10 | 317,588.70 | 16,306.60 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **564,215.40** | **578,578.70** | 14,363.30 |

Бараа материалын дансны үлдэгдэл 123,988.6 мянган төгрөг болж өмнөх оноос 32,625.0 мянган төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 128,420.3 мянган төгрөг, өөрийн хөрөнгөөр 120,069.5 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүй 3,563.3 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч бүртгэсэн. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 9,321.3 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 454,590.1 мянган төгрөг болж 18,001.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар захирамжаар 7,927.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,749,513.9 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 295,757.3 мянган төгрөгөөр бууруулж, 1,453,756.6 мянган төгрөгөөр баталсан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,453,756.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,239,949.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 895,904.00 | 689,989.70 | 205,914.30 | 77.02 |
| 2 | 80236 Эрсдэлийн болон НБҮ хийх | 4,176.00 | 4,176.00 | - | 100.00 |
| 3 | 80237 Хамгаалах, нөхөн сэргэх үйлчилгээний зардал | 301,102.10 | 301,022.02 | 80.08 | 99.97 |
| 4 | 80238 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | 198,068.40 | 197,997.36 | 71.04 | 99.96 |
| 5 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 46,658.30 | 38,923.20 | 7,735.10 | 83.42 |
| 6 | 83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөл | 7,847.80 | 7,841.02 | 6.78 | 99.91 |
| Нийт | | 1,453,756.60 | 1,239,949.30 | 213,807.30 | 93.38 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 356,562.5 мянган төгрөг орсныг 147,101.0 мянган төгрөгийг хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны зардалд, 62,001.6 мянган төгрөгийг хуримын үйл ажиллагааны зардалд, хүүхэд харах үйлчилгээний зардалд 60,612.6 мянган төгрөг, бусад үйл ажиллагааны зардалд 86,783.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 63.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн дансны орлогын дэлгэрэнгүй*

| № | Байгууллагын нэр | Орлого |
|---|---|---|
| 1 | Зуслангийн орлого | 153,140.90 |
| 2 | Хуримын орлого | 68,173.00 |
| 4 | ХГБХХЕГазар | 67,886.60 |
| 5 | НҮБ | 19,100.00 |
| 6 | Баянхонгор аймгийн Засаг дарга | 48,262.00 |
| Нийт | | 356,562.50 |

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 20,378.1 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2,494.2 мянган төгрөг, Баянхонгор Хөвших Од ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,453,756.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,537.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,176.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 6,500.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг дутуу мэдээлсэн байсныг аудитын явцад нөхөн мэдээлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Батчимэг гүйцэтгэж аудитаар 48,041.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,638.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1,658.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 04 дугаар сарын 29-ний өдрийн 202 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 3 | 1,638.00 | 3 | 1,638.00 | 100% |
| Албан шаардлага | 1 | 48,041.50 | 1 | 48,041.50 | 100% |
| Зөвлөмж | 1 | 1,658.20 | 1 | 1,658.20 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **51,337.70** | **5** | **51,337.70** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

------------oOo------------



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ